

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Далхаагийн Намхай	Дугаар	L058
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Хэрлэн сум
Төрсөн газар	Дорнод аймаг хэрлэн сум Чойбалсан хот	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ялгуулсны Дээд болон Доод хийд	Сүм хийдийн дугаар	ДОЧБ 011, ДОЧБ 012
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 10	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Чойбалсан сумын Ялгуулсны Дээд болон Доод хийд

-Дорнод аймагт байсан сүм хийдүүдийн тухай таны сонссон дуулсан, судалж үзсэн юм юу байна. Энэ тухайгаа бидэнд хэлж өгөхгүй юу?

Манай аймгийн хувьд том бага нийлсэн жар орчим хийд, хүрээ, дацан, дуган байсан гэж би ойлгодог. Энэ нутагт хамгийн анх бий болсон хийд нь Ялгуусан хутагтын баруун, зүүн хийд юм. Өөрөөр хэлбэл хөгшин хүрээ, Ламын хийд гэсэн нэг нь 40 гаруй ламтай нөгөөх нь 300-аад ламтай, нэг гүвээний хоёр талд ойрхон хоёр хийд юм. Дараагаар нь энэ аймгийн төв дээр Хойд хүрээ, Урд хүрээ гэж хоёр том хийд байсан. Урд хүрээ нь ламаар олон, хойд хүрээ нь барилга байгууламж, хурал, дэгээрээ өөр байсан. Мөн Дэчин гэгээний хийд гээд жижигхэн хийд байсан. Матад тийш Арын хамба бас жижгэвтэр хийд байсан. Энэ хийдийн цаад талд Алтан-Очиртын хийд гэж том хийд байсан байна. Мөн тэндээс 4,5 км-т Мэргэн бандидын хийд гээд нэлээд нэлээд томоохон хийд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байсан. Мөн хошуу хийд, ер нь хошуу бүхэн хийдтэй байжээ. Хэцүү То вангийн хийд Утай таван уулын хийд уг нь өөр нэртэй байх ёстой.

Ялгуусан хутагтын талаар Нэргүй нэдэг хүн “Ил товчоо” /1990-1997онд / сонинд “Захын Ялгуусан хутагт” гэж нэлээд томоохон юм хэвлүүлсэн. Саяхан Захын Ялгуусны шавь байсан Чой-Осор гэж өвгөн Чойбалсанд байж байгаад нас барсан. Тэр Чой-Осор гэдэг өвгөн, сүнсгүй Шарав гуай энэ хоёр шавь нь хүрээ хийдэд нь сууж хүмүүс бөгөөд Чой-Осор гуайн яриаг тэр сонинд гаргасан. Ялгуусан ламын найман дүр тодорсон гэдэг. Сүүлийн дүр нь 21,23-тай ч баригдсан гэж ярьдаг. Төрсөн газар нь энэ зүүн тийш Хутаг уулын зүүн хойхно байдаг.

Манай хошууны хамгийн сүүлийн ноён Тогтохтөр 29, Ялгуусан лам 23тай, нэг нь ноён, нэг нь лам хоёр нь болж байжээ. Энэ хоёр хоёулаа “Лхүмбийн хэрэг” гэдэгт орж баригдсан.